

**МОНОС ХҮНС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтыг удирдлага болгон Монос хүнс ХК-ийн 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн, хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Монос хүнс ХК-ийн 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг энэхүү тогтоолын хавсралт №01-ээр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ

Монос Хүнс ХК-ийн 2025 оны санхүү, үйл ажиллагааны тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Монос Хүнс ХК нь эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэлийн салбарт тэргүүлэгч үндэсний үйлдвэрлэгчийн хувьд 17,000 гаруй хувьцаа эзэмшигчдийнхээ итгэл, дэмжлэгт тулгуурлан 2025 онд хариуцлагатай засаглал, тогтвортой өсөлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлж ажиллалаа. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү дүгнэлтийг компанийн 2025 оны улирал, жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, санхүүгийн хөндлөнгийн аудитын (Онч аудит ХХК) дүгнэлт, ТУЗ-ийн дэргэдэх хороодын санал, зөвлөмжид үндэслэн гаргав.

Үйл ажиллагаа, стратегийн хэрэгжилтийн үнэлгээ

2025 он Монос Хүнс ХК-ийн хувьд үйлдвэрлэл, логистик, зах зээлийн чиглэлд тэлэлт, шилжилтийг хийж, түүний үр өгөөжийг гаргаж эхэлсэн онцлог жил байлаа.

“MFC 2.0” нэгдсэн үйлдвэрийн төсөл хэрэгжиж эхэлснээр хуурай болон шингэн хүнсний үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, эрэлтээс хамаарсан бүтээгдэхүүний тасалдал буурч бүтээмж нэмэгдсэн.

“MFC East Log” зүүн бүсийн агуулах, логистикийн төслийг эхлүүлсэн нь Монгол улсын замын түгжрэлийн хүндрэлтэй нөхцөлд түгээлтийн цэг хамралт, нэгж цэгийн түгээлтэд зарцуулах дундаж хугацаа, туулах зам, зардлыг дунд хугацаанд бууруулах, түгээлтийн үр ашгийг нэмэгдүүлэх суурь нөхцөл бүрдүүлсэн оновчтой шийдвэр гэж үзэн Төлөөлөн удирдах зөвлөл дэмжсэн.

Компанийн дунд, урт хугацааны өсөлтийн стратегийн чухал чиглэл болох экспортын үйл ажиллагаанд 2025 онд бодит ахиц гарсан. Үүнд: АНУ болон Австралийн зах зээлд “Lifecykel” компанитай хамтын ажиллагаа эхлүүлж, Өтгөн барагшуун, Чацарганын цэвэр тос зэрэг бүтээгдэхүүнүүдийг олон улсын FDA стандартын дагуу баталгаажуулсан нь экспортын нэг алхам болж байна. Бид хэрэглэгчдийн хэрэглээний зан төлөв, өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг урьдчилан тодорхойлж, дэвшилтэт техник, технологийн инновацийг тасралтгүй нэвтрүүлэхийн зэрэгцээ бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэлийн стандартыг тогтмол сайжруулж байна.

Санхүүгийн гүйцэтгэлийн үнэлгээ

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчид 4 мянгаас 17 мянга болж 4.3 дахин өссөн, компанийн сүүлийн 5 жилийн дунджаар борлуулалт 32%, цэвэр ашиг 51%-ийн өсөлттэй, ашигт ажиллагаа, хөрөнгийн өгөөж нэмэгдэхийн зэрэгцээ, үнэ ашгийн харьцаа (P/E) 4.4 болжээ.

2025 оны гүйцэтгэлээр компанийн борлуулалтын орлого 27%-иар өсөж, нийт орлого 48 тэрбум төгрөгт хүрсэн. Хөрөнгө оруулалт, тэлэлтийг дагасан мөнгөн урсгал, зардал өндөр байсан хэдий ч цэвэр ашиг 7.7 тэрбум төгрөгт хүрч ашигт ажиллагааны түвшин сайжирсан нь “MFC 2.0” төслийн өгөөж гарч бүтээмжид нөлөөлсөн, санхүүгийн сахилга бат, удирдлага үр дүнтэй байсныг харуулж байна.

ТУЗ нь 2025 оны санхүүгийн үр дүнд үндэслэн нэгж хувьцаанд 4.5 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн нь компанийн мөнгөн урсгал, ирээдүйн хөрөнгө оруулалтын хэрэгцээ болон хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг тэнцвэржүүлэх зарчимд нийцсэн гэж үзсэн.

Засаглал, эрсдэлийн удирдлага

Бидний стратегийн зорилго нь зөвхөн богино хугацааны борлуулалтын өсөлтөд төвлөрөх бус, урт хугацаанд тогтвортой хөгжил, хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, засаглал, эрсдэлийн удирдлага, инноваци, хүний нөөцийн хөгжлийг цогцоор нь бодлогын түвшинд удирдахыг зорино.

2025 онд компанийн хэмжээнд нийт 68 эрсдэлийг тодорхойлон, ангилж, стратегийн хариу арга хэмжээг төлөвлөн, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.

Хотын баруун бүсэд үйлдвэрийн үйл ажиллагаа төвлөрснөөр ажилтны гарах урсгал нэмэгдэх бодит эрсдэлтэй тулгарсан ч ажлын орчныг сайжруулах, удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, цалин урамшууллын оновчтой бодлогыг хэрэгжүүлснээр үйлдвэрийн салбарын ажиллах хүчний дутмаг он жилүүдэд компанийн ажлаас гаралтын индекс 26.7 хувь болж буурсан нь сайшаалтай юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг тогтвортой авч хэрэгжүүлэн биелэлтийг Нийслэлийн байгаль орчны газраас хараат бусаар 6 гишүүн тус бүр үнэлж дүгнэдэг, 2025 оны дүгнэлтээр 8 бүлэг үзүүлэлтээр 95%-ийн үнэлгээтэй дүгнэжээ.

FSSC 22000 (Хүнсний аюулгүй байдал), ISO 9001 (Чанарын удирдлагын тогтолцоо), ISO 14001 (Байгаль орчны удирдлагын тогтолцоо) зэрэг Нэгдсэн Удирдлагын Тогтолцоог хэвшүүлж тасралтгүй үйл ажиллагааны тэргүүний шаардлага болох бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг олон улсын хөндлөнгийн аудитын “SGS” компаниар дахин амжилттай баталгаажууллаа.

ТУЗ нь тайлант хугацаанд идэвхтэй ажиллаж, стратеги, хөрөнгө оруулалт, засаглалын гол шийдвэрүүдийг хуулийн хүрээнд ил тод, хариуцлагатайгаар гаргасан гэж дүгнэлээ.

Компанийн удирдлага, хамт олон стратегийн зорилтоо бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлд үр дүнтэй ажилласан гэж үзэн, Төлөөлөн удирдах зөвлөл нь Монос Хүнс ХК-ийн 2025 оны үйл ажиллагааг “МАШ САЙН” гэж дүгнэв.

Компанийн өнөөгийн амжилт нь удирдлага хамт олны нэгдмэл зорилго, үнэт зүйлс, тууштай хөдөлмөр, мөн хувьцаа эзэмшигч, харилцагч, түнш байгууллагуудын итгэл, дэмжлэгийн бодит илэрхийлэл юм.

Бид цаашид ч эрүүл мэндийн хүнсний салбар дахь манлайлагчийн байр сууриа бататган, инноваци, хариуцлагатай засаглал, тогтвортой хөгжлийн зарчимд тулгуурлан үнэ цэнийг бүтээсээр байх болно.

Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл

**МОНОС ХҮНС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтыг удирдлага болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос гаргасан саналыг 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээг болон хурлын үйл ажиллагаанд шаардагдах 2026 оны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №01-д заасны дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолоор батлагдсан төсөвт хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулал хорооны дарга (Х.Ананд)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Н.УЛААНХҮҮ



2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
..... тоот тогтоолын Хавсралт №01

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсөв

	/мянган төгрөг/
1. ТУЗ-ийн хурлын үйл ажиллагааны зардал	12,000
2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, НДШ	348,563
3. Засаглал, хөгжлийн зардал	5,000
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зардал	30,000
НИЙТ ДҮН	395,563